



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2017 оны 06 сарын 23 өдөр

Дугаар 05

Сүхбаатар

Өргөдөл хянан шалгасан тухай

Сүхбаатар сумын 3 дугаар цэцэрлэгийн эрхлэгч П.Амарсанаагийн “Аймгийн Засаг даргын 2017 оны Б/18 тоот захирамжийг хүчингүй болгох тухай” өргөдлийг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2017 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаар хэлэлцээд, Монгол Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам, ”Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29.2.2, Захиргааны Ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, Авлигатай тэмцэх газрын 2017 оны 05/3536 албан тоотыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2017 оны 04 сарын 28-ны өдрийн Б/18 тоот “Сахилгын шийтгэл ноогдуулах тухай” захирамжийг эрх зүйн үндэслэлтэй гэж үзсүгэй.

ДАРГА



Ө.СУВДАА